

Товьёг

Д/д	Товч утга	Хуудасны тоо	Хуудасны дугаар
1	Улсын их хурлын тогтоол	1	2-3
2	Засгийн газрын тогтоол	4	3-6
3	Засгийн газрын албан даалгавар	2	6-7
4	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	2	7-8
5	Ерөнхий сайдын албан даалгавар	1	9
6	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол	1	10
7	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал	7	11-17

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Орхон аймаг

2025.06.25

Д/д	Шийдвэрийн нэр, огноо	Зүйл заалтын дугаар	Зүйл, заалтын агуулга	Хэрэгжилтийн тайлан	Хэрэгжилтийн хувь	Хэрэгжээгүй шалтгаан	Хяналтаас хасах үндэслэл
1	2	3	4	5	6	7	8
Улсын Их Хурлын тогтоол							
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай 2024.04.18	2	Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7, 6.8, 6.9 дэх хэсэгт заасны дагуу үндсэн чиглэл, хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Ёс зүйн хороо, Засгийн газрын, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо, бүх шатны томилох эрх бүхий албан тушаалтанд тус тус даалгасугай.	Тус газрын Ёс зүйн дэд хороо нь Төрийн албан хаагчдын сахилга хариуцлага, ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах зорилгоор шинээр батлагдан гарсан хууль, журам тогтоол шийдвэрүүдийг өөрийн байгууллагын онцлог, чиг үүрэгтэй уялдуулан жилийн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж байна. Нийгмийн даатгалын байгууллагын ажилтануудыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, харилцаа хандлагыг сайжруулах, байгууллагын соёлыг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх зорилгоор сургалт арга хэмжээнүүдийг шат дараатайгаар хэрэгжүүлэн ажилласан. Үүнд: - “Ёс зүйгээрээ манлайлагч хэлтэс” болзолт уралдаан	100%		

				- “Бид соёлыг бүтээнэ, бид соёлыг түгээнэ” Нөлөөллийн арга хэмжээ - Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ёс зүйн хэм хэмжээ, танин мэдэхүйн ойлголт өгөх зорилготой Хөгжөөнт тоглоом - Ёс зүйн тухай ойлголт рийл - “Ёс зүйтэй хариуцлагатай төрийн алба” “Та өгөхгүй бид авахгүй” пост - Ажилчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулах хяналт тавих, идэвхижүүлэх зорилгоор “Өглөөг өөдрөг эхлүүлье” арга хэмжээг тус тус зохион байгуулсан.			
Хэсгийн дундаж: 100 хувь							
Засгийн газрын тогтоол							
1.	Журам батлах тухай Дугаар 422 2023.11.29	1.1-7.2	“Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас даатгуулагч эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр авахад бүрдүүлэх баримт, бичгийн жагсаалт болон төлбөрийг олгох санхүүжүүлэх журам”	ЗГ-ын 2023 оны 11 сарын 29-ний өдрийн Дугаар 422 журмын дагуу ҮОМШӨ-ний даатгалын сангаас даатгуулагчид сэргээн засах төв болон сувиллыг зардлын төлбөрт 145 хүнд 116 сая төгрөг, унааны зардалд 4 хүнд 286,2 мянган төгрөгийг хуулийн хугацаанд шийдвэрлэж олгосон. Протез, ортопедын төлбөр авах хүсэлт ирээгүй байна.	100%		
2.	Танилт, нэвтрэлтийн арга, хэрэгсэл батлах тухай Дугаар 217 2024.12.18	2.2	Хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхэд танилт, нэвтрэлтийн системийг ашиглахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга нарт болон төрийн захиргааны	Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2024 оноос эхлэн Нийгмийн даатгалын цогц систем болох https://portal.ndaatgal.mn/ -ийг ашиглаж байгаа бөгөөд Орхон аймгийн Нийгмийн даатгалд	100%		

			бүх шатны байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай.	бүртгэлтэй 1362 ажил олгогчоос, давхардсан тоогоор 15,874 удаагийн шимтгэл төлөлтийн тайланг хүлээн авсан байна. Мөн 23,822 албан журмын даатгуулагчийн 279,538 удаагийн мэдээллийг Portal.ndaatgal.mn цахим системээр дамжуулан хүлээн авч регистрийн дугаар, иргэний бүртгэлийн дугаар, татвар төлөгчийн дугаар, гадаадын иргэний бүртгэлийн дугаараар шалган, баталгаажуулалт хийсэн. Иргэд даатгуулагчид болон ажил олгогчид дээрх системд Танилт нэвтрэлтийн DAN симтемээр нэвтэрч нийгмийн даатгалын бүх төрлийн үйлчилгээ авах боломж бүрдсэн.			
3.	Төрийн байгууллагын үйл ажиллагааны цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай №163 тогтоол 2024.11.13	2	Төрийн захиргааны байгууллагын албан хэрэгцээнд ашиглах баримт бичиг боловсруулах программ хангамжийн лицензийг Ерөнхий гэрээгээр худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу нэгдсэн журмаар зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд Т.Доржхандад, холбогдох зардлыг төсвийн багцдаа тусган санхүүжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус үүрэг болгосугай.	Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд "Able" программыг нэвтрүүлэн ажиллаж байгаа бөгөөд Хүний нөөц, албан бичиг солилцоо, ажлын цаг бүртгэл, хурал, тушаал шийдвэр, архивын лавлагаа, олон нийтийн зар гэсэн хэсэгүүдээс бүрдсэн цогц системийг ашиглаж байна.	100%		

4.	Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай №109 2024.10.02	2	Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолын хавсралтаар баталсан ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн батлан хэрэгжүүлэх, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай	Ёс зүйн дэд хорооны гишүүн Л.Эрдэнэсүвд МУ-ын Засгийн газрын 2024.10.02-ны өдрийн "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ" батлах тухай 109 дүгээр тогтоолыг албан хаагчдад танилцуулж, Тогтоол гарсантай холбогдуулан байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар зүйлд өөрчлөлт оруулсан тухай сургалт, мэдээллийг Хүний нөөц хуулийн мэргэжилтэн Д.Идэржавхлан ажилтан албан хаагчдад танилцуулж ажилласан. Сургалтад нийт ТЗ-ны болон ТҮ-ний 29 ажилтан албан хаагчийг хамруулсан.	100%		
5.	Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим системийн талаар авах арга хэмжээний тухай №196 2024.05.08	3	"Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем"-ийг ашиглан эрхлэх асуудлынхаа хүрээндээ төрийн албан хаагчийн мэдээллийн бүрдүүлэлт, үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай	ХНУМТ цахим системд ажилтан албан хаагчдын Ерөнхий мэдээллийг бүрэн гүйцэт оруулах, ажилласан жилийг НД-ын шимтгэл төлөлтийн мэдээлэлтэй тулгах, ажил эрхлэлтийн түүхийг зөв оруулсан эсэхийг хянах, шагналын болон бусад мэдээллийг бүрэн гүйцэт оруулах ажлуудыг үе шаттайгаар хийсэн. Дээрх ажлуудыг хийж гүйцэтгэсний дараа https://www.csc.gov.mn/ -ийн Төрийн албан хаагчийн портал цэсээр нэвтэрч албан хаагчид өөрсдийн мэдээллээ бүрэн баталгаажуулж дууссан. 2025 оны 06 сарын 20-ны өдрийн байдлаар Хүний нөөцийн системд албан хаагчдын АТТ-ын холбох ажил явагдаж байна. Байгууллагын	100%		

				хүсэлт илгээх-Салбар зөвлөл хянах-ТАЗ хянах-ТАЗ шийдвэр оруулах-Байгууллага АТТ оруулах-Салбар зөвлөл хянах-Байгууллага тушаал оруулах гэсэн үндсэн процесс ажиллагаатай бөгөөд тус газрын хувьд Байгууллага АТТ оруулах хэсэгт дээр ажиллаж байна.			
Хэсгийн дундаж: 100 хувь							
Засгийн газрын албан даалгавар №2025-03,							
1.	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхтэй холбогдуулан 2025 оны эхний хагаст орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний тухай	1.8	Бүс, орон нутгийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, халамжаас хөдөлмөрт шилжүүлэх зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлэх;	Тус газар нь залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх, залуучуудыг төрийн албанд бэлтгэх, нийгмийг соён гэгээрүүлэх үндсэн зорилгоор "Нийгмийн даатгалын төлөөлөгч" төсөл хөтөлбөрийг аймаг орон нутгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2025 онд 5 ажилтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулан ажиллаж байна. Аймгийн Засаг даргын 2025 оны А/79 тоот захирамжаар төлөөлөгчдийн цалинд 59.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон.	100%		
		1.4	Бүс, орон нутгийнхаа сайн туршлага, шинэ санаачилга, инновац нэвтрүүлсэн туршлагыг олон нийтэд таниулах, түгээх, бусад аймаг, нийслэлтэй туршлага солилцох	1.Монгол Улсын төрийн албаны зөвлөлөөс “Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал” Хойд бүсийн зөвлөгөөн Орхон аймагт зохион байгуулагдсан бөгөөд Тус зөвлөгөөнөөр Нийгмийн даатгалын газарт нэвтрүүлэн ажиллаж буй 9-н “Тэргүүн туршлага” танилцуулж	100%		

				оролцсон. 2. Мөн "Төрийн албаны реформ-бидний шийдэл" судалгаа, эрдэм шинжилгээний бүтээлийн уралдаанд "Төрийн байгууллага сэтгэл зүйн дархлаатай байх арга замыг эрэлхийлэх нь" сэдэвт эрдэм шинжилгээний илтгэлээр оролцсон бөгөөд тус Уралдаанд оролцсон илтгэлээ "Сэтгэл зүйн дархлаатай төрийн байгууллага" нэртэй төсөл болгон өргөжүүлж "Эдийн засгийн форум-2025" арга хэмжээнд төрийн байгууллагууд болон Олон улсын донор байгууллагуудад танилцуулж ажилласан. 3. Мөн нийгмийн даатгалын байгууллагын нэвтрүүлсэн Авлигын эсрэг стандарт ISO37001:2016, Чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 стандартуудыг төрийн болон хувийн хэвшлийн 10 гаруй байгууллагуудад танилцуулж туршлага судлан ажилласан.			
Хэсгийн дундаж: 100 хувь							
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл							
1.	Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдааны 31 дүгээр тэмдэглэл 2024.09.04	31.9.6. 2	Төрийн байгууллагын "gov.mn" нэгдсэн цахим хуудаст мэдээллийг байршуулах, тухай бүр шинэчлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Хагас жилийн байдлаар Нийгмийн даатгалын сангийн 73 мэдээлэл, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 68 мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдээлж ажилласан. 1-р улиралын үнэлгээгээр Нийгмийн даатгалын газар 96.67%-тай үнэлүүлсэн. 1 мэдээ хоцроосон үзүүлэлттэй байна. Тус газрын Хяналт шалгалтын хэлтсээс 2025 оны 01-р улирлын	100%		

				Шилэн дансны цахим хуудсанд Нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл байршуулсан байдал, холбогдох шийдвэрийн хуулбар, баримт бичгийг бүрэн оруулсан эсэхэд 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөс 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн хугацаанд хяналт шалгалт хийж ажилласан. Гарсан дутагдал зөрчлийг дахин гаргахгүй байх, хугацаа хоцроохгүй байх талаар зөвлөмжийг мэдээлэл байршуулах ажилтан, албан хаагчдад өгч ажилласан.			
2.	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэл	10.19.4.2.	Холбогдох хууль тогтоомжоор өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг богино хугацаанд шуурхай зохион байгуулан бүрэн хангахад анхаарч, эрхлэх асуудлын хүрээнд дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	1.ГБХНХСайдын 2025.02.25-ны өдрийн Шилэн дансны тухай хууль болон холбогдох хууль журмыг хэрэгжүүлэн ажиллах тухай 03 дугаар албан даалгаварын дагуу улирал бүр мэдээллээ байршуулан ажиллаж байна. Үнэлгээний хувь 97.6% үнэлэгдсэн. 2. Монгол улсын Ерөнхий сайдын 2025.03.07-ны өдрийн 03 дугаар албан даалгаврын 1.4 хэсэгт заасны дугуу тус байгууллагын хэрэгжүүлсэн 9- "тэргүүн туршлага", мөн ISO9001:2015, ISO37001:2016 стандарт, "Төрийн байгууллага сэтгэл зүйн дархлаатай байх арга замыг ирэлхийлэх нь" гэх мэт төсөл арга хэмжээг танилцуулж харилцан туршлага солилцсон. Мөн 1.6 дахь хэсэгт заасны дагуу иргэд аж ахуй нэгж байгууллагын өргөдөл хүсэлтийг шуурхай шийдвэрлэж хагас жилийн байдлаар 91 өргөдөл	100%		

				хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. Шийдвэрлэлтийн хувь 88% байна. Шийдвэрлэх шатандаа явж буй өргөдөл 12% эзэлж байна. 3. НДЕГ-ын даргын 2025.03.14-ны өдрийн 01 албан даалгаврын дагуу 4 зорилт 23 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулан улирал бүр хэрэгжилтийг ханган ажиллаж байна.			
Хэсгийн дундаж: 100 хувь							
Ерөнхий сайдын албан даалгавар							
1.	Албан даалгавар 2025.02.25	03	“Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах тухай”	Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн 68 болон сангийн 72 мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой 1 мэдээллийг хоцорч байршуулсан үзүүлэлттэй байна. 2025.06.09-ний өдрийн байдлаар 141 мэдээллийг байршуулсан. Тус газрын Захиргаа хяналтын хэлтсээс мэдээлэл байршуулдаг албан хаагчидтай уулзалт хийж дээд газрын шалгалтаар илэрсэн зөрчилийг давтан гаргахгүй байхад чиглэсэн заавар өгч, шалгалтын явцад засах боломжтой 1 алдаагаа залруулж, ирүүлсэн чиглэлийг хэрэгжүүлэн ажилласан. 1-р улирлын хяналтын тайланг цахим хуудсанд байршуулсан.	100%		
Хэсгийн дундаж: 100 хувь							

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол							
1	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны “Журам батлах тухай” 02 дугаар тогтоол	02	“Даатгуулагчид тусламж үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувиллыг сонгох гэрээ байгуулах, санхүүжүүлэх, тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих журам”	Даатгуулагчид тусламж үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувиллыг сонгох шалгаруулалтын дагуу тэнцсэн нэр бүхий 4 рашаан сувилалд хэвтэн эмчлүүлсэн ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр авдаг 145 хүний 116 сая төгрөгний сувиллын зардлыг олгосон бол 4 хүний 286200 төгрөгийн унааны зардлыг олгоод байна.	100%		
2	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны “Журам батлах тухай” 07 дугаар тогтоол	07	"Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих журам"	"Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих журам"-ын дагуу НДЕГ-ын 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан 3 арга хэмжээний хүрээнд сургалт зохион байгуулах төсвийн хуваарьт Орхон аймгийн хэмжээнд сургалт, сурталчилгаанд зориулсан төсөв 32,5 сая төгрөг батлагдан орж ирсэн. Орхон аймгийн НДГ-ын даргын 2025.05.15-ны өдрийн А/21 тоот тушаалаар төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох, хяналт тавих Үнэлгээний хороог 6 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.	100%		

Хэсгийн дундаж: 100 хувь

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал							
1.	НДЕГ-ын 2025.01.20-ны өдрийн тушаал	A/10	“2025 онд нийгмийн даатгалд шинээр хамруулах ажил олгогч албан журмаар даатгуулагч сайн дураар даатгуулагчийн тооны төлөвлөгөө”	2025 оны эхний хагас жилийн байдлаар сайн дурын даатгалд нийт 3737 даатгуулагч хамрагдсан байна. Үүнд: - Энгийн сайн дурын даатгуулагч 2750 - Малчин даатгуулагч – 274 - Тэтгэмжийн даатгалын сангаас хариуцан төлж байгаа 0-3 хүртэлх настай хүүхдээ асарч байгаа эх – 334 - Улсын төсвөөс хариуцан төлж байгаа 0-3 хүртэлх настай хүүхдээ асарч байгаа эх – 260 - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асардаг эцэг, эх даатгуулагч – 119 тус тус даатгуулсан байна. Эхний хагас жил шинээр сайн дурын даатгуулагч малчин 40 иргэн хамруулж ажилласан байна. Мөн 2025 оны эхний хагас жилд шинээр 88 аж ахуй нэгж байгууллага хамруулж, даатгуулагчийн тоог 173-аар нэмэгдүүлэн ажилласан байна.	100%		
2	НДЕГ-ын даргын 2025.02.11	A/26	Тушаалд өөрчлөлт оруулах тухай	Орхон аймгийн Жаргалант сумын 1 байцаагчийн хоол унааны нэмэгдлийг A/26 тоот тушаалын дагуу өдрийн 10.000 төгрөгөөр тооцон олгож байна.	100%		
3	НДЕГ-ын даргын 2025.03.21	A/68	Хяналт шинжилгээний ажил зохион байгуулах тухай	Нийгмийн даатгалын газрын даргын 2024 онд гаргасан захиргааны акт болох А-48, Б-78 нийт 126 тушаалыг	100%		

				цахимаар заасан хугацаанд хүргэж, нэмэлтээр үндэслэн аймгаас гарсан шийдвэр, тушаал холбогдох заалтуулыг хүргүүлж ажилласан.			
4.	НДЕГ-ын даргын 2023.06.14-ний өдөр	A/92	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/92 дугаар тушаалаар баталсан Нийгмийн даатгалын байгууллагын эд хөрөнгийн тооллого явуулах журам	2025 оны хагас жилийн байдлаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 06 сарын 14-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/92 тушаалыг үндэслэн тус газрын Өмч хамгаалах байнгын зөвлөл нь үндсэн хөрөнгийн тооллогыг журмын дагуу хийж тайлан, мэдээ, судалгааг холбогдох газруудад хуулийн хугацаанд хүргүүлж ажилласан. - Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тайланг “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем” програмд оруулж ажилласан. - Хагас жилийн тооллогоор үнэ тогтоолгох, шилжүүлэх, актлах, хөрөнгийн жагсаалтыг гаргаж хүргүүлсэн. - Газрын даргын 2025.01.25 өдрийн А/3 дугаар тушаалаар тооллогын комисс томилогдон ажиллаж 2025 оны төлөвлөгөө батлуулан, өмч хөрөнгийн тооллого хийж дүгнэлт гарган даргын зөвлөлийн хуралд танилцуулсан.	100%		

				- Ашиглалтын хугацаа дуусаж,эвдэрч гэмтсэн үндсэн хөрөнгийн судалгааг гаргаж, актлах,хугацааг сунгах 22 нэр төрлийн 72 ширхэг 23,941,588 төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгө жагсаалтыг дээд газарт хүргүүлсэн.			
5.	НДЕГ-ын даргын 2025.02.10-ны өдрийн тушаал	A/15	“Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай”	Төсвийн хуваарийн дагуу сар бүрийн орлого, зардалаа тооцоолон ажиллаж байна.	100%		
6.	НДЕГ-ын даргын 2025.02.28-ны өдрийн тушаал	A/47	Нэрэмжит жилтэй холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан “Даатгуулагчийг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах жилийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөө батлах тухай”	2025 оныг “Нийгмийн даатгалын өр, авлага барагдуулах, даатгуулагчийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан Нэрэмжит жилийн төлөвлөгөөг 3 зорилт 28 арга хэмжээтэйгээр төлөвлөн ажиллаж биелэлтийн сар бүр хүргүүлэн ажиллаж байна.	100%		
7	НДЕГ-ын даргын 2025.03.11-ний өдрийн тушаал	A/51	“Газрын даргын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” A/51, 03 дугаар сарын 25-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай”	Нийгмийн даатгалын газрын даргын зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанд тухай бүр оролцож байна. Орхон аймагтай хамаарал бүхий Ажилгүйдлийн даатгалын санд хийсэн хяналт шалгалтын дүнгийн хурал, ЭММЗ-ийн үйл ажиллагаанд хийсэн дахин магадлалын үр дүн, нэрэмжит жилийн хүрээнд хийхээр дэвшүүлж буй санал санаачлага, 2025 оны нэгдүгээр хагас жилийн ажлын гүйцэтгэл хамгаалах тайлангийн хурал зэрэг цахим хурлуудад тайлан мэдээлэл хүргэж, Газрын даргын зөвлөлийн	100%		

				гишүүдийн асуултад хариулж оролцсон.			
8	НДЕГ-ын даргын 2025.03.11-ний өдрийн тушаал	A/50 A/49	“Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” A/50, Үйл ажиллагааны урсгал зардлын 2025 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” A/49 дугаар тушаал	Төсвийн хуваарийн дагуу сар бүрийн орлого, зардалаа тооцоолон ажиллаж байна.	100%		
9	НДЕГ-ын даргын 2025.03.28-ны өдрийн тушаал	A/74	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 07 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө”	Орхон аймгийн НДГ-ын даргын 2025.05.15-ны өдрийн A/21 тоот тушаалаар төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох, хяналт тавих Үнэлгээний хороог 6 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Үнэлгээний хороо 2 удаа хуралдаж урьдчилан сэргийлэх арга хэмжээний дагуу сургалт сурталчилгаа хийх байгууллага шалгаруулах 3 төрлийн зарыг олон нийтийн сүлжээнд байршуулсан. Сонгон шалгаруулалтанд 1 байгууллага материалаа ирүүлээд байна.	100%		
10	НДЕГ-ын даргын 2025.03.29-ны өдрийн тушаал	A/75	“Аудитын акт, албан шаардлага, зөвлөмж хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай” A/75 дугаар тушаал	Дүгнэлтэнд заагдсан зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг хугацаанд явуулж тооцоо нийлсэн.	100%		
11.	НДЕГ-ын даргын 2025.03.31-ны өдрийн тушаал	A/34	“Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Ахмадын зөвлөлийн дүрэм”, “Ахмадын сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах журам”-ыг шинэчлэн	Нийгмийн даатгалын Газрын даргын 2025 оны A/20 тоот тушаалаар Орхон аймгийн НДГ-ын Ахмадын зөвлөлийн дүрмийг боловсруулан	100%		

			баталсантай холбогдуулан аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх "Ахмадын зөвлөлийн дүрэм"	баталж Ахмадын зөвлөлд танилцуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус газрын 22 ахмад ажилтны судалгааг гаргаж ерөнхий газарт хүргүүлсэн.			
12	НДЕГ-ын даргын 2025.04.23-ны өдрийн тушаал	A/98	"Сургалт зохион байгуулах тухай" A/98 дугаар тушаал	НДЕГ-аас нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдыг чадавхжуулахаар зохион байгуулсан сургалтанд 2025 оны 04 дүгээр сарын 28-29-ний өдрүүдэд сайн дурын даатгал хариуцсан байцаагч О.Чойенмаа, Тэтгэвэр тогтоолт, олголт хариуцсан байцаагч Д.Цэгмид нар хамрагдаж нийгмийн даатгалын мэдээллийн SICOS системийн шинэчлэл өөрчлөлттэй танилцаж, системийн талаар нэгдсэн ойлголттой болж сургагч багшийн үнэмлэх гардан авч уг сургалтанд амжилттай хамрагдсан.	100%		
13	НДЕГ-ын даргын 2025.04.24-ны өдрийн тушаал	A/104	"Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгон гадаад улсад амьдарч байгаа иргэдийг дахин магадлах хяналт шалгалтын удирдамж батлах тухай" A/104 тушаал	Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгон гадаад улсад амьдарч байгаа иргэдийг дахин магадлах хяналт шалгалтын удирдамж батлах тухай Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын A/104 тоот тушаалын хэрэгжилтийг хангах үүднээс 9-н Өрхийн эрүүл мэндийн төв болон Жаргалант сумын ЭМТ-д судалгаа гаргуулах тухай албан тоот илгээснээр 06 сарын байдлаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон 2 иргэн гадаадад	100%		

				амьдарч байна. /Цэцэгдарь Саруулмаа-МХ84040902 Данзан Хишигжаргал-ХО70040504/ Франц улсад амьдарч буй Данзангийн Хишигжаргал-ХО70040504 нь 2025 оны 03 дугаар сард ХЧА-ын хувь хугацаа цуцлагдсан байна.			
14	НДЕГ-ын даргын 2025.04.24-ны өдрийн тушаал	A/105	Улсын их хурлын 2023 оны “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” 59 дүгээр тогтоолын хавсралтаар “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2023-2030”	Тус газар нь Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн Зорилт 2.5-ийн 2.5.2.1 ,2.6.2.1, Зорилт 6.4-ийн 6.4.11.1, Зорилт 7.1-ийн 7.1.2.1, 7.1.2.2, Зорилт 9.2-ийн 9.2.1.1, 9.5.2.1 дэх заалтын хэрэгжилтийг гаргаж дээд шатны байгууллагад тайлагнаж ажилласан. Мөн нийгмийн даатгалын газрын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 19 арга хэмжээ төлөвлөж, хагас жилийн хэрэгжилтийн тайлан болон Соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан зохион байгуулсан ажлын бичмэл тайланг нотлох баримтын хамт НДЕГ-т заасан хугацаанд хүргүүлсэн.	100%		
15	НДЕГ-ын даргын 2025.05.06, 2025.05.20 тушаал	A/129 A/143	“Үйл ажиллагааны урсгал зардлын 2025 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” A/129, “Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” A/143 дугаар тушаал	2025 оны үндсэн үйл ажиллагааны зардал 1,676,458.1 мянган төгрөгийн төлөвлөгөөтэй бөгөөд хагас жилийн байдлаар 810,597.0 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна.	100%		

16	НДЕГ-ын даргын 2025.04.24-ны өдрийн тушаал	A/103	Нийгмийн даатгалын шимтгэлийн болон сангийн өр төлбөр барагдуулахад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартай хамтран ажиллах 2025 оны төлөвлөгөө, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нартай хамтран ажиллах үүрэг бүхий “Ажлын хэсэг” байгуулах тухай	Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй шүүхийн шийдвэртэй 13 аж ахуйн нэгж байгууллагын 1420609,7 мян төгрөгийн өр авлагыг тулган баталгаажуулж судалгааг гаргаж Нийгмийн даатгалын ерөнхий газрын ШХАЗУГ-т хүргүүлэн ажилласан.	100%		
Нийт дундаж: 100 хувь							

Биелэлтийн товчоо

Д/д	Зорилт арга хэмжээ	Арга хэмжээний тоо	Үүнээс				Хэрэгжилтийн тооцох хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
			100% биелсэн	Хэрэгжих шатандаа				
				70%	30%	0%		
1.	Улсын их хурлын тогтоол	1						100%
2.	Засгийн газрын тогтоол	5						100%
3.	Засгийн газрын албан даалгавар	1						100%
4.	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	2						100%
5.	Ерөнхий сайдын албан даалгавар	1						100%
6.	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол	2						100%
7.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал	16						100%
			Нийт	100%				

Хэрэгжилтийг хянасан:

ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН

ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ.....

/Д.НАРМАНДАХ/

Хэрэгжилтийг нэгтгэн тайлагнасан:

ХҮНИЙ НӨӨЦ, ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

/Д.ИДЭРЖАВХЛАН/

